



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2018 оны 05 сарын 16 өдөр

Дугаар А/188

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрөл олгох,
түдгэлзүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2, 19.3, 19.20.6, 19.21 Эрүүл мэндийн яамны "Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комисс"-ын 2018 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр болон нэмэлтээр олгох байгууллагын нэрсийг нэгдүгээр, түдгэлзүүлэх байгууллагын нэрсийг хоёрдугаар, нэр өөрчлөх байгууллагын нэрсийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Б.Цогтбаатар/-т үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дэд сайд /Л.Бямбасүрэн/-д даалгасугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

080820

Эрүүл мэндийн сайдын 2018 оны
05... сарын 16 өдрийн 4 дугаар
тушаалын 1 дүгээр хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ШИНЭЭР БОЛОН НЭМЭЛТЭЭР ОЛГОХ
БАЙГУУЛЛАГЫН НЭР, ЧИГЛЭЛ, ХУГАЦАА

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Тусгай зөвшөөрлийн хугацаа
Шинээр тусгай зөвшөөрөл олгох байгууллага			
1	Арима фарм ХХК	эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхит бүтээгдэхүүн, урвалж оношлуур импортлох ханган нийлүүлэх	3 жил
2	Ариун мед трейд ХХК	эмнэлгийн тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл импортлох, ханган нийлүүлэх	3 жил
3	Мэг про ХХК	протез, ортопед үйлдвэрлэх	3 жил
4	Тэгш Анар ХХК	эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох, ханган нийлүүлэх	3 жил
5	Доктор ма ХХК	эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох, ханган нийлүүлэх	3 жил
6	Ориентал нова ХХК	биологийн идэвхит бүтээгдэхүүн импортлох, ханган нийлүүлэх	3 жил
7	МК бридж партнерс ХХК	эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох, ханган нийлүүлэх	3 жил
8	Өнөр болор ХХК	Клиник /Нүүр амны өвчний тусламж үйлчилгээ/	3 жил
9	Архон ХХК	биологийн идэвхит бүтээгдэхүүн импортлох ханган нийлүүлэх	3 жил
10	Амин хүчил төрөгч ХХК	эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж импортлох ханган нийлүүлэх	3 жил

Эрүүл мэндийн сайдын
2018 оны 2 сарын 1 өдрийн
А/188 дугаар тушаалын 2 дугаар хавсралт



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ТҮДГЭЛЗҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГЫН
НЭР, ЧИГЛЭЛ, ХУГАЦАА

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Тусгай зөвшөөрлийн хугацаа
1.	Өү жи юу ХХК	Клиник /Нүүр амны тусламж үйлчилгээ/	3 сар

Эрүүл мэндийн сайдын
2018 оны 05 сарын 14 өдрийн
А/188. дугаар тушаалын 3 дугаар хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН НЭР ӨӨРЧЛӨХ БАЙГУУЛЛАГЫН
НЭР, ЧИГЛЭЛ, ХУГАЦАА

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Тусгай зөвшөөрлийн хугацаа
1.	Долоон Одой медикал ХХК	Клиник/Хүүхэд, эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээ/	3 жил